



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын хураангуй тайлан

Аудитын сэдэв: Аудитад Баян-Өлгий аймагт 2019-2023 онд хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэв.

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЗОХИХ ҮР ДҮНГЭЭ ӨГСӨН БАЙНА

Аудитын тайланг хүргүүлсэн этгээд: Үндэсний аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Хүүхэд, гэр бүл, хөгжлийн хамгааллын газар, Боловсролын газар

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: У.Ербол

Утас: 94159291 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Аудитор: Х.Манаргүл

Аудитын харилцан хамаарал:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дагуу хийсэн.

Баян-Өлгий аймагт 2019-2023 онд хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар болон аймаг, сумын ИТХ, Засаг дарга түүний харьяа байгууллагуудыг хамруулан ажлын төлөвлөгөө, тайлан, мэдээ, судалгаа, олгосон санхүүжилт, түүний зарцуулалт, дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хамруулав.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилт, үр дүнг эрсдэлтэй гэж үзсэн нь аудит хийх гол шалтгаан юм.

Аудитын дүнг Үндэсний аудитын газарт хүргүүлснээр улсын хэмжээнд нэгтгэгдэж нэгдсэн дүн гарч, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилго, зорилтууд, хамарсан хүрээ:

Баян-Өлгий аймагт хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.Үүнд:

- Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, тогтолцоо оновчтой эсэх
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх
- Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх

Аудитад Баян-Өлгий аймагт 2019-2023 онд хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар болон аймаг, сумын ИТХ, Засаг дарга түүний харьяа байгууллагуудыг хамруулан ажлын төлөвлөгөө, тайлан, мэдээ, судалгаа, олгосон санхүүжилт, түүний зарцуулалт, дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хамруулав.

Аудит хийхэд гарсан хүндрэл бэрхшээл: Аймгийн Эрүүл мэндийн газраас эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалалтай холбоотой баримт, материал ирүүлээгүй болно

Аудитын гол үр дүн:

1.2.2 Хүүхдийн төлөө зөвлөл, Засаг дарга нарын зарим чиг үүрэгээ хэрэгжээгүй байна

Аймгийн ХГБХХГ хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан боловч хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаар аймгийн онцлогт тохируулан бодлого, төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байсан ба хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

Аймгийн Засаг даргын захирамжаар 2018, 2021 онуудад аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийг байгуулж, Хүүхдийн төлөө зөвлөлийн дүрмийг баталсан боловч дараах чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн дүрмийн 4.1.2-т заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй, зөвлөлөөс гарсан ямар нэг шийдвэр, хурлын тэмдэглэл байхгүй, зөвлөлийн нарийн бичиг, гишүүд дүрмийн 5 дугаар зүйлд заасан үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- Дүрмийн 4.1.7-д “Зөвлөл нь өөрийн цахим хуудастай байна. Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг цахим хуудсаар дамжуулан шуурхай ажил хэрэг болгох үүднээс ашиглана” гэж заалт хэрэгжээгүй, цахим хуудасгүй байна.
- Сумын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжаар 12 сумд Хүүхдийн төлөө зөвлөл байгуулан ажиллуулж байгаа боловч Дэлүүн сум 2021 оноос хойш Хүүхдийн төлөө зөвлөл байгуулж ажиллаагүй байна.
- Сумуудын Хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, мэдээнээс үзэхэд 11 сум тогтмол үйл ажиллагаа явуулж, хуралдаж байсан ба Бугат сумын Засаг дарга томилогдоогүйгээс 2023 онд үйл ажиллагаа явуулаагүй байна.

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт 2.4-ийн 2.4.2, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5-ын 2.5.1.1, 2.5.2.3-т заасны дагуу дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвд 6.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий “Хүүхэд хамгаалал, хөгжил төв”-ийн барилгын ажлыг 2021 оноос барьж байгаа ба 2023 оны байдлаар 35.4 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17.1.3-т заасан чиг үүргийн хүрээнд 2020-2022 онд жил бүр 2.5 сая төгрөгийг хууль зүйн туслалцааны зардалд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Эх хүүхдийн дэмжих санд 2021-2022 онд жил бүр 10.0 сая төгрөгийг батлуулж, хэрэгжүүлсэн байна.

Харин дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаагүй байна Үүнд:

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17.1.5-т заасан чиг үүргийн хүрээнд аймгийн ХГБХХГ-ын ажлын хэсэг 2023 онд аймгийн төвийн 24 тоглоомын талбайд хяналт шалгалт хийсэн тайлангаас үзэхэд тоглоомууд нь хуучирч эвдэрснээс хүүхэд тоглох боломжгүй болсон байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/270 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг Хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу холбогдох хууль тогтоомжуудад нийцүүлэн гаргасан дүрэм журам, стандартын биелэлтэд хяналт тавьж, дараах зөрчлийг тогтоож хугацаатай албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй зэрэг аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл болон Засаг дарга нарын холбогдох хууль журамд заасан хүүхэд хамгааллын талаарх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллахыг талаар зөвлөмж өгөв.

1.2.5 Хүүхэд хамгааллын талаар нэгдсэн мэдээллийн сангийн программ байхгүй байна

Хүүхэд хамгааллын талаар гаргасан жил бүрийн нэгдсэн мэдээ, судалгааг ексел файлаар “folder” үүсгэн хадгалдаг ба нэгдсэн мэдээллийн сангийн программ байхгүй байна..

1.2.6 Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулах орон тоо дутагдалтай байна

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын бүтэц орон тоог аймгийн Засаг даргын 2019 оны А/283 дугаар захирамжаар 20, 2020 оны А/155 дугаар захирамжаар 15, 2021 оны А/127 дугаар захирамжаар 14 орон тоогоор баталсан байна. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн А/55 дугаар тушаалаар 19 орон тоогоор баталсныг мөрдөж ажилласан байна.

Ажлын байрны тодорхойлолтоос үзэхэд хүүхэд хөгжил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, хүүхдийн эрх хамгаалал хариуцсан мэргэжилтэн, хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн, хүүхдийн эрхийн улсын байцаагч тус бүр 1, бүгд 4 орон тоо ажиллаж хүүхэд хамгааллын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцаж ажилласан байна.

Аудитын явцад 2019-2023 оны эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоог хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн тоотой харьцуулж үзэхэд харьцангуй бага хувьтай хүүхэд хариу үйлчилгээ авч байгаа нь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх боловсон хүчний дутагдалтай, хүүхэд бүрт хүрч ажиллаж чадахгүй байгаатай холбоотой байна.

Мөн тус аймгийн хүүхдийн тоог баруун бүсийн аймгуудтай харьцуулж үзэхэд хүүхдийн тоо бусад аймгуудаас харьцангуй их мөртлөө, нийт орон тоо 5-16 орон

тоогоор бага байгаа нь тус аймгийн хүүхэд хамгааллын талаар хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйлчилгээг бүрэн хэрэгжүүлж чадахгүй байх эрсдэлтэй байна.

2.1.1 Хүүхэд хамгааллын зардлын төсвийг үндэслэлтэй төлөвлөх шаардлагатай байна

Аймгийн ХГБХХГ-ын хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 2019 онд 84.9 сая төгрөг, 2020 онд 84.9 сая төгрөг, 2021 онд 84.9 сая төгрөг, 2022 онд 113.7 сая төгрөг, 2023 онд 111.1 сая төгрөг нийтдээ 479.5 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

ХГБХХГ-т хүүхэд хамгаалалын чиглэлээр хуваарилж буй төсвийг урьд жилүүдээс нэмэгдүүлж төлөвлөсөн боловч хүүхдийн хөгжил хамгаалал, шуурхай тусламж үйлчилгээ, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээг хүргэхэд санхүүжилт дутагдалтай байгаа тул төсвийг хүүхдийн тоо, ажлын ачааллыг харгалзан судалгаанд үндэслэн төлөвлөх шаардлагатай байна.

2.1.2 Урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн төлөвлөлт оновчтой бус байна

Хүүхэд хамгааллын нийт төсвийн 2019 онд 56.5 хувь, 2020 онд 48.3 хувь, 2021 онд 47.3 хувь, 2022 онд 45.1 хувь, 2023 онд 32.2 хувийг хүүхдийн эрсдэлд нөхцлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулахаар төсөвлөсөн байна.

2021-2023 онд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан хүүхдийн тоо, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан хүүхэд доторх эрсдэлт бүлэгт байгаа хүүхдийн тоо тус тус өссөн боловч урьдчилан сэргийлэх зардалд батлагдсан төсвийг 2023 онд 2022 оноос 30.0 хувь буюу 15.4 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн байна.

Өөрөөр хэлбэл хүүхдийн хүчирхийлэл нэмэгдэж байгаа болон үйлчилгээний эрэлт хэрэгцээ өсөж байгаа боловч хүүхэд хамгаалалд урьдчилсан арга хэмжээний төсвийг бууруулж баталж байгаа нь санхүүжилтийн төлөвлөлт оновчтой бус байгааг харуулж байна.

2.1.3 Хүүхэд хамгааллын зардлын 60.6 хувийг хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд хуваарилсан байна

Аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 оны төсөвт нөхцөл байдлын үнэлгээ хийх зардалд 2.4-11.2 сая төгрөг, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардалд 36.9-67.3 сая төгрөг, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 84.9-113.7 сая төгрөгийн төсөв баталсан. Гүйцэтгэлээр нөхцөл байдлын үнэлгээ хийх зардалд 6.0-7.8 сая төгрөг, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардалд 12.5-67.3 сая төгрөг, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 84.9-111.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

2023 онд хүүхэд хамгааллын зардлын 60.6 хувийг буюу 67.3 сая төгрөгийг хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүүхэд хамгааллын нийт төсөв 2019 онд 84.9 сая төгрөг байсан бол 2023 онд 111.1 сая төгрөг болж 30.8 хувиар өссөн байна. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын 2023 онд төсвийг 2022 онд баталсан төсвөөс 30.0 хувиар буюу 15.4 сая төгрөгөөр бууруулж баталсан нь төсвийн хувиарлалт оновчгүй байгааг харуулж байна.

2.2.1 Хүүхэд хамгааллын төсвөөс 2019 онд 41.6 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна

Аймгийн ХГБХХГ нь хүүхэд хамгааллын төсвийг нөхцөл байдлын үнэлгээ, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэсэн 3 төрлийн үйлчилгээнд төлөвлөсний дагуу 2021 онд 84.9, 2021 онд 84.9, 2021 онд 77.9, 2021 онд 99.4, 2022 онд 111.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

ХГБХХГ нь 2019, 2020, 2023 онд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан бол 2021 онд 7.0, 2022 онд 14.3 сая төгрөгийг хэмнэсэн байна.

2.2.4 Хүүхэд хамгааллын үйлчилгээг зохих журмаар хэрэгжүүлж ажилласан байна

Тус аймагт хүүхэд хамгааллын талаар 2019-2023 онд дараах ажлуудыг зохих журмын дагуу хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн ЗДТГ, НҮБ-ын Хүн амын сантай хамтран гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг түр байршуулан хамгаалах үйлчилгээ үзүүлэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг байгуулан зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.
- Нэг цэгийн үйлчилгээний төвд 2019 онд 50, 2020 онд 30, 2021 онд 25, 2022 онд 90, 2023 онд 103 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байна.
- Аймгийн Засаг даргын дэргэдэх түр хамгаалах байранд 2019 онд 16, 2020 онд 10, 2021 онд 1, 2022 онд 23, 2023 онд 30 хүүхдэд үйлчилгээ үзүүлж ажилласан байна.
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн аймгийн Засаг даргын 2018 оны А/940, 2022 оны А/948 дугаар захирамжуудаар Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулан тус хороогоор 2019-2023 онд 124 хүүхэд үйлчилүүлсэн зэрэг байна.
- Аймгийн хэмжээнд хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 27 хамтарсан баг ажиллаж 2019 онд 120, 2020 онд 38, 2021 онд 47, 2022 онд 76, 2023 онд 172 кейст нөхцөл байдлын үнэлгээ хийж, эрх нь зөрчигдсөн хүүхдэд холбогдох хууль, журмын дагуу үйлчилгээ үзүүлсэн байна.
- Сумдад зохион байгуулагдсан Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний үеэр 11 сумын Хамтарсан багийн 128 гишүүдтэй уулзалт хийж, удирдлага арга зүйгээр хангаж, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг холбон зуучилж нийгэм, сэтгэл зүйн боловсролын хамгааллын цогц үйлчилгээг “Жаннур” ТББ-аар дамжуулан хэрэгжүүлсэн байна.

2.2.6 Хамтарсан багийн урьдчилан сэргийлэх болон хариу үйлчилгээнд үзүүлэхэд төсөв нь оновчгүй байна

Аймгийн хэмжээнд хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 27 Хамтарсан багт давхардсан тоогоор 284 гишүүн ажиллаж ирсэн байна. ХГБХХГ-аас хамтарсан багт 2021 онд 2.7 сая төгрөгийн, 2022 онд 0.4 сая төгрөгийн, 2023 онд 5.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Энэ нь эрүүл мэндийн төлбөртэй тусламж үйлчилгээний зардал, тусгай хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээний зардал, үйлчилгээ авч буй хүүхдэд шаардлагатай хөгжлийн үйлчилгээний зардал /тоглоом, ном, дэвтэр, харандаа, тээвэр шатахуун, хүнс, эм хэрэгсэл, хувцас, түлээ түлш, ариун цэврийн хэрэгсэл/, хамтарсан багийн гишүүдийн үйл ажиллагааг дэмжих зардал /цай, кофе/ болон хамтарсан багийн гишүүдэд олгосон урамшуулал, томилолтын зардлууд байна.

Мөн Хууль зүй дотоод хэргийн яамнаас аймгийн 27 хамтарсан баг бүрт 2021 онд 8.1 сая төгрөг, 2022 онд 8.4 сая төгрөг, 2023 онд 8.4 сая төгрөгийн санхүүжилт хуваарилсан ба зохих журмын дагуу зарцуулсан байна.

3.1.1 Боловсролын салбараас бусад салбарт оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт, аргачлал байхгүй байна

БСШУСС-ын 2019 оны А/803 тоот тушаалаар “Цэцэрлэг, ЕБС-ийн үйл ажиллагааг үнэлэх журам”, 2020 оны А/269 тушаалаар “Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын өөрийн үнэлгээний загвар”, БШУС-ын 2022 оны А/453 тушаалаар “ЕБС, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ыг баталсан ба боловсролын салбарын үйл ажиллагааг дээрх журмуудын хүрээнд дүгнэж, хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Бусад салбарын байгууллагуудад хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн болон үйл ажиллагааг үнэлж дүгнэх салбарын онцлогт нийцсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлал байхгүй байна.

3.1.5. Бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, тайлагнаж ажилласан байна

Аймгийн ИТХ-ын 2020 оны 13 дугаар тогтоолоор “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх “Хөгжилд тэмүүлсэн Баян-Өлгий” үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс дээрх бодлогын хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж, дүгнэлт гаргаж, төлөвлөсөн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан ба бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн биелэлт, тайланг хяналт-шинжилгээг үнэлгээний нээлттэй цахим сан буюу unelgee.gov.mn-д тайлагнасан байна.

Аймгийн ХГБХХГ-аас 2023 онд Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэлийн шийдвэрлэлт, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, дүгнэлт гарган, зөвлөмж өгч ажилласан байна.

3.2.1 Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт гэр бүлийн орчинд бүрэн нөлөөлж чадахгүй байна


Аймгийн ХГБХХГ-аас гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулах, эцэг эхийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2019-2023 онд нөлөөллийн арга хэмжээг танхимаар болон цахимаар хийж, сургалт зохион байгуулж, сургагч багш бэлтгэн, “Хүүхдээ хамгаалъя”, “Гэр бүлийн хүчирхийллийг бууруулахад-Бидний оролцоо” аяныг зохион байгуулсан байна.

Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд төрөл бүрийн постер, стикер хэвлүүлж, шторк, видео, постер бэлтгэж төрийн болон төрийн бус байгууллагад хүргүүлэн, ухуулгын ажил зохион байгуулж орон нутгийн радиогоор олон нийтэд хүргэсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 66, 67 дугаар тогтоолоор “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах”, “Гэр бүлийн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг батлуулан, уг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэлэлцүүлэг, уулзалт, лекц, чуулган, хууль сурталчлах өдөрлөг зохион байгуулж, явуулын үйлчилгээ үзүүлж, шторк бэлдэн байгууллагын веб сайт, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээсэн байна.

Аймгийн ХГБХХГ-аас дээрх ажлуудыг зохион байгуулж ажиллаж байгаа боловч гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо буурахгүй байна.

Дүрслэл №03 Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд



Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээ

Судалгаанаас үзэхэд тус аймагт 2019-2023 онд 992 хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо 2023 онд 284 болж өмнөх онтой харьцуулахад 2019 оноос 133 хүүхдээр, 2020 оноос 14 хүүхдээр, 2021 оноос 177 хүүхдээр, 2022 оноос 104 хүүхдээр өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо нэмэгдсэнийг харуулж байгаа боловч нөгөө талаас гэр бүлийн орчинд хүүхдийн эрхийг хангах, хамгаалах ажлын хүрээнд дээр дурдсан ажлуудыг зохион байгуулсны үр дүнд гэр бүлийн орчинд хүүхдийн эрхийн зөрчлийг мэдээлдэг, тусламж дэмжлэг хүсдэг тохиолдлын тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитаар гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн ХГБХХГ-т зөвлөмж болгов.

3.2.2. Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлого бүрэн хэрэгжээгүй байна.

Аудитад аймгийн Боловсролын газар, Өлгий сумын ерөнхий боловсролын нийт 8 сургууль, хүүхдийн 11 цэцэрлэг, хувийн хэвшлийн “Бастама”, “Эмпати” сургууль, Толбо сумын ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, хүүхдийн цэцэрлэг хамрагдав.

Аймгийн Боловсролын газраас 2019-2022 онд ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын талаарх хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг ирүүлээгүй бөгөөд 2023 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.Үүнд:

ЕБС-ын орчин дахь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт:

- Боловсролын газрын даргын баталсан хөтөлбөрийн дагуу “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үүрэг хариуцлага”, “Тэгш хамран сургах боловсролын үзэл санааг хэрэгжүүлэх арга зүй” сэдэвт шат дараалсан сургалт, Норвегийн тусламжийн байгууллагатай хамтран “Хүн бүрт ээлтэй хүртээмжтэй Баян-Өлгий” аяны хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулсан
- Аймгийн ЗДТГ, ХГБХХГ-тай хамтарч “Хүүхдийн эрхийг дээдэлье” хүүхдийн чуулган зохион байгуулж “Хүүхэд хамгаалалд тулгамдаж буй асуудлууд”, “Насанд хүрээгүй хүүхдээс үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчил, түүний шалтгаан нөхцөл”, “Сургуулийн орчин дахь хүүхэд хамгаалал”, “Хүүхдийн эрүүл мэндэд тулгамдаж буй асуудал” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.
- Шинэ хичээлийн жилийн нээлттэй холбогдуулан сурагч, хүүхэд багачуудыг гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд “Хичээл эхэллээ” арга хэмжээг зохион байгуулж, “Хүүхдийн хөгжил, хүмүүжил, хамгаалал”, “Дотуур байр миний гэр”, “Тэгш хамран сургалт-тэгш хүртээмжит боловсрол” дэд хөтөлбөрүүдийг аймгийн Засаг даргаар батлуулан, хэрэгжүүлсэн.
- БЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй”, “Найз байя” аян, Хүүхдийг орчны болон ахуйн болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор аймгийн ХГБХХГ, ЕБС-ийн хамгааллын багтай хамтран “Хамтдаа шалгая, хамгаалъя” арга хэмжээг зохион байгуулсан.
- БЕГ, ЦЕГ болон ХГБХХГ-ын хамтран хэрэгжүүлсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргээс өсвөр насны хүүхэд, залуучуудыг урьдчилан сэргийлэх, хорт зуршлаас ангид байлгах “АНЗААР” арга хэмжээг сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтан, багш, эцэг эх, асран хамгаалагч, ахлах ангийн сурагчдын оролцоотойгоор зохион байгуулж, орон нутгийн радио, телевизээр сурталчилсан.

СӨБ-ын орчин дахь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт:

- Дэлхийн Зөн Олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгээр орон нутгийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалт, “Бага

насны хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах мэдлэг чадвар олгох” сургалтыг БШУЯ, МЭХ-тай хамтран зохион байгуулж, гарын авлага, сургамжит түүх өгүүлэг, CD бэлдэж, казак хэл дээр орчуулан бүх цэцэрлэг, эцэг эх, асран хамгаалагч нарт хүргүүлсэн байна.

- 2022-2023 оны хичээлийн жилд аймгийн Цагдаагийн газартай хамтран “Хамтарсан багийн гишүүдийн чадавхыг бэхжүүлэх”, “Хүүхдийн эрх, хүчирхийллийн хэлбэр төрлүүд”, “Бага насны хүүхдийг хүчирхийллээс хамгаалах арга зүй” сэдэвт сургалт, 2023-2024 оны хичээлийн жилд нийт багш, ажилтан, эцэг эх, олон нийтэд чиглэсэн 247 нөлөөллийн ажил, 140 үзүүлэх сургалт зохион байгуулжээ.

Аудитаар аймгийн төвийн ерөнхий боловсролын нийт 11 сургуулийг хамруулан ЕБС-ийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхдээ хөтөлбөр гаргаж ажиллаагүй байна.
2. Хүүхдүүдийн санаачилгаар байгуулагдсан өөрийн удирдлага болон сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагаа явуулдаг өрөө тасалгаа байхгүй.
3. Ерөнхий боловсролын нийт 5 сургуулийн гадаад болон дотоод орчинд хүүхдэд учирч болзошгүй нөхцөл байдалд эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй, өндөр эрсдэлтэй үйл ажиллагааны жагсаалтыг гарган эрсдэлийг бууруулах арга хэмжээг үе шаттай авч, хэрэгжүүлээгүй
4. Хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоож, хүчирхийллээс үүдэлтэй эсэхэд тандалт судалгааны ажил хийгдээгүй.
5. Яаралтай үед хүүхэд ашиглаж болох утасны цэг, анхны тусламжийн хайрцагийг тодорхой цэгт байрлуулж ажиллуулаагүй.
6. Сургууль, дотуур байрны орчинд хүүхэдтэй шууд болон шууд бус харьцах удирдах ажилтан, багш, ажилтныг ажилд авахдаа өмнөх ажилласан газрын ажлын байрны тодорхойлолт, хүчирхийлэл, гэмт хэрэгт холбогдож байсан эсэхийг нотлох эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг аваагүй, хувийн хэрэгт хавсраагүй.
7. Багшийн ёс зүйн дүрмийн заалтуудыг шинээр ажилд орсон багш, ажилтанд танилцуулж, хүлээн зөвшөөрсөн гарын үсгийг зуруулж ажиллаагүй байна.
8. Өлгий сумын ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн хажууд шатахуун түгээх станц үйл ажиллагаа явуулдаг, гал, түймэр гарах эрсдэлтэй,
9. Өлгий сумын ерөнхий боловсролын 3, 6 дугаар сургуулийн багш, ажилтан, сурагчдын явах замын гарцад барилга барьснаас хоёр машин зөрөх боломжгүй болсон, сурагчид сургуульд ирэх, гэртээ харихдаа явган хүний зам байхгүйгээс авто машины дундуур явдаг, замын тэмдэг, тэмдэглээ, автомашины зогсоолгүй.
10. Өлгий сумын ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн барилга нь стандартын шаардлага хангахгүй, цэвэр, бохир усны шугамд холбогдоогүй, гадна орчны талбай хүрэлцээ муу, сургуулийн барилга нь авто замд ойрхон, хурд сааруулагч,

замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглээ дутмаг буюу “ЕБС-ийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS 6782:2019” стандартын шаардлагыг хангахгүй.

11. Боловсролын газар ажлын тайлан, судалгаа, мэдээг "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын дагуу архивын хадгаламжийн нэгж үүсгэж хадгалаагүй байна.

Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллыг сайжруулахын тулд хүүхэд хамгааллын бодлогыг боловсронгуй болгох, хамтарсан багт ажилладаг цагдаа, өрхийн эмнэлгийн ажилтнуудын ажил үүргийн хуваарьт хүүхэд хамгааллын ажлыг оруулах, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв буюу хүүхэд хамгааллын зардлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Аудитад хамрагдсан нийт 12 хүүхдийн цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Хүүхдийн нийт 6 цэцэрлэг хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр гаргаж ажиллаагүй.
2. СӨБ-ын нийт 11 цэцэрлэг багийн гишүүдэд нууцлалын гэрээ хийгээгүй, шинээр багш, ажилтан сонгон шалгаруулж авахдаа өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаар цагдаагийн тодорхойлолт аваагүй, анкетад хавсраагүй.
3. СӨБ-ын нийт 8 цэцэрлэг бодлогын баримт бичиг болон дүрэм, журам, эрсдэлийн зураглалыг олон нийтэд харагдахуйц газарт байршуулаагүй, эрсдэлд өртөж болзошгүй хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, нийгэм-сэтгэл зүйн байдлын талаар үнэлгээ хийгээгүй, мэдээллийн сан бүрдүүлж ажиллаагүй, хүүхэд, гэр бүлийн талаарх мэдээллийн нууцлалыг хадгалах ажил хангалтгүй, зориулалтын сейфгүй.
4. Өлгий сумын 10, 11, 23, 24 дугаар цэцэрлэг, 18 дугаар цэцэрлэгийн салбар бүлэг түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд барилга нь стандартын шаардлага хангахгүй, цэвэр, бохир усны шугамд холбогдоогүй, гадна орчны талбай хүрэлцээ муу, цэцэрлэгийн барилга нь авто замд ойрхон, хурд сааруулагч, замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглээ дутмаг буюу “СӨБ-ийн байгууллагын сургалтын орчин ерөнхий шаардлага MNS 6558:2015” стандартын шаардлагыг хангахгүй байна.

Аудитын дүнгээр аймгийн Боловсролын газарт хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт, хяналтыг сайжруулахтай холбоотой **7 зөвлөмж** өгөв.

3.2.3. Аймгийн Эрүүл мэндийн газар хууль тогтоомжид заасан чиг үүргээ биелүүлээгүй байна

Аудитын явцад аймгийн Эрүүл мэндийн газрын холбогдох албан тушаалтнуудтай 2 удаа уулзалт хийж, аудитаар шалгах асуудлын талаар танилцуулсан боловч ямар ч материал ирүүлээгүй болно.

3.2.4. Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалалд анхаарах шаардлагатай байна

Сүүлийн үед цахим техник ашиглах (интернет, сошиал медиа, фэйсбүүк, гар утас) боломж нэмэгдэх хэрээр хүүхдийн эрх ашиг хөндөгдөх, зөрчигдөх шинэ орчин тэлж, хүүхдүүдийн цахим орчин дахь дарамт, хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэл нэмэгдсэн байна.

Хүснэгт №10 Цахим орчинд дахь хүчирхийлэл, мөлжлөг

Хүчирхийлэл, мөлжлөгийн хэлбэрүүд	Цахим ба Хэвлэл мэдээллийн орчинд					
	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	нийт
Бэлгийн хүчирхийллийн хохирогч	0	0	4	0	0	4
Сэтгэл санааны хүчирхийллийн хохирогч	5	4	6	0	9	24

Эх сурвалж: Аймгийн ХГБХХ-ын статистик мэдээ, судалгаа

Цахим орчинд 2019-2023 онд нийт 28 хүчирхийллийн тохиолдол бүртгэгдсэний 24 буюу 85.7% нь сэтгэл санааны, 4 буюу 14.3 % нь бэлгийн хүчирхийллийн хохирогч байна.

Цахим орчин дахь сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо 2023 онд 9 бүртгэгдэж, өмнөх онуудтай харьцуулахад 1.5-2.5 дахин нэмэгдсэн бол 2022 онд бүртгэгдээгүй байна. 2021 онд цахим орчин дахь бэлгийн хүчирхийллийн 4 тохиолдол бүртгэгдсэн байна.

Аймгийн ХГБХХГ-аас дэмжих, холбон зуучлах үйлчилгээний хүрээнд 2019 онд 5, 2020 онд 3, 2021 онд 5, 2023 онд 6 хүүхэд сэтгэл зүйн зөвлөгөө авсан байна.

Аудитын явцад ЕБС-ийн удирдлага, нийгмийн ажилтнуудтай хийсэн ярилцлага, судалгааны дүнгээс харахад Facebook ашигладаг хүүхдүүдийн цахим хэрэглээний ойлголт дутмаг, профайл нууцлалын тохиргоог мэдэхгүйгээс хувийн нууцаа алдах, цахим дарамт, гадуурхал, гэмт хэрэгт өртөх магадлал өндөр байна. Сүүлийн үед гар утас ашигладаг сурагчдын тоо эрс нэмэгдсэнтэй холбоотой цахим орчин дахь хүчирхийлэл нэмэгдэх эрсдэлтэй байна гэж хариулсан байна.

Сургуулийн орчин дахь үе тэнгийн дээрэлхэлт цахим орчин руу илүү шилжиж, хүүхдүүд нийгмийн сүлжээгээр бие биеэ гутаан доромжлох, худал мэдээлэл тараах явдал түгээмэл боловч нууцлагдмал байдалтай явагддаг гэдгийг дурджээ.

Цахим технологийн сөрөг нөлөө, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй тул хүүхдийн эрхийг зөрчсөн вэбсайтыг мэдээлэх цахим талбар, эцэг эхийн хяналтын аппликэйшн зэргийг хөгжүүлж, сургуулийн орчинд гар утас ашиглахыг хязгаарлах эрх зүйн акт гаргах нь зүйтэй байна.

Аудитаар цахим орчин, хэвлэл мэдээллийн орчин дахь хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн ХГБХХГ-т зөвлөмж болгов.

3.2.5. Олон нийтийн арга хэмжээ, соёл, спортын үйл ажиллагаанд хүүхэд хамгаалал зохих түвшинд хангагдсан байна

Аймгийн ХГБХХГ-т 2019-2023 онд бүртгэгдсэн статистик тоо, мэдээллийг харуулбал;

Хүснэгт №11 Олон нийтийн газар, бусад орчин дахь хүчирхийлэл

Хүчирхийлэл, мөлжлөгийн хэлбэрүүд	Олон нийтийн газар, бусад орчин дахь хүчирхийлэл					Нийт
	2019	2020	2021	2022	2023	
Бие махбодын хүчирхийллийн хохирогч	4	4	3	1	0	12
Бэлгийн хүчирхийллийн хохирогч	2	4	0	3	4	13
Сэтгэл санааны хүчирхийллийн хохирогч	6	29	14	2	68	119
Үл хайхрах байдлын хохирогч	35	35	5	7	18	100

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээ, судалгаа

Олон нийтийн болон соёл, спортын үйл ажиллагааны орчинд 2019-2023 онд нийт 244 хүчирхийлэл бүртгэгдсэний 119 буюу 48.7% нь сэтгэл санааны, 100 буюу 41% нь үл хайхрах байдлын, 13 буюу 5.3% нь бэлгийн хүчирхийллийн, 12 буюу 5 % нь бие махбодын хүчирхийллийн хохирогч байна.

Сэтгэл санааны хүчирхийллийн хохирогч 2023 онд өмнөх онуудтай харьцуулахад эрс нэмэгдсэн бол үл хайхрах байдлын хохирогч сүүлийн жилүүдэд буурсан үзүүлэлттэй байна.

ЕБС, СӨБ-ийн удирдлага, нийгмийн ажилтан, арга зүйч нартай хийсэн ярилцлагын тэмдэглэл, судалгааны дүнгээс харахад хүүхдүүдийг олон нийтийн арга хэмжээ, соёл, спортын үйл ажиллагаанд оролцуулахдаа эцэг эх, асран хамгаалагч нартай хамт зохион байгуулдаг, гэхдээ бичгээр зөвшөөрөл аваагүй гэж хариулсан байна.

3.2.6. Гамшгийн онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллыг хангах талаар тодорхой ажлуудыг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна

Аймгийн Онцгой байдлын газраас 2019-2023 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны чиглэлээр: “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2022 оны

А/190 дүгээр захирамж гаргуулан гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн бэлтгэл ажлын ерөнхий болон календарчилсан төлөвлөгөөг боловсруулж батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд ЕБ-ын нийт 11 сургуульд “Гамшгаас хамгаалах менежмент”, “Гамшгийн үеийн мэдээллийн нийтэд хүргэх хэвлэл мэдээллийн зохион байгуулалт”, “Гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба, мэргэжлийн ангийн чиг үүрэг, дадлага зохион байгуулах заавар”, “Гамшгийн нөхцөл байдал хариу арга хэмжээ”, “Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам”, “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний эрх зүйн шинэчлэл” зэрэг сэдвүүдээр танхимын болон дадлага сургалт, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан гамшгаас хамгаалах 12 алба, гамшгаас хамгаалах 21 мэргэжлийн ангийн ажилтан алба хаагч нарт сургалт зохион байгуулсан байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны чиглэлээр:

МУЗГ-ын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар баталсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын хүрээнд 2021-2022 онд Өлгий сумын ЕБС, цэцэрлэгүүдийн удирдлага, багш, сурагч, ажилтнуудын төлөөллийг хамруулан гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж гүйцэтгэсэн байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг, шалган зааварлах ухуулга сурталчилгааны ажил, “Аюулгүй галлагаа” “Бяцхан үрсээ болзошгүй эрсдэлээс хамгаалъя” “Үер уснаас үрсээ хамгаалъя” “Яндангаа хөөлье - Өнөтэй өвөлжье”, “Бэлэн бай” зэрэг аяныг зохион байгуулж санамж, сэрэмжлүүлэг тараасан байна.

Цэцэрлэг, ЕБС-ийн сурагчдад 2019-2023 онд нийт 65 удаа, 120 цагийн гамшгаас хамгаалах ангиллын сургалт, дадлагын ажлыг зохион байгуулсан байна.

Галын аюулгүй байдлыг хангах хяналт шалгалтын чиглэлээр:

Аймгийн ОБГ-ын дарга, аймгийн ерөнхий прокурор, Цагдаагийн газрын дарга нарын “Их, дээд сургууль, коллеж, ЕБС-ийн оюутан, сурагчдын дотуур байранд гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг хангах” тухай хамтран баталсан удирдамжийн дагуу хууль тогтоомж, журам, стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд дээд сургууль, коллеж, ЕБС-ийн оюутан, сурагчдын дотуур байранд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг хангуулсан байна.

ОБЕГ-ын даргын 2023 оны “Боловсролын байгууллагын барилга байгууламжид гамшгаас хамгаалах, галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт, шалгалт зохион байгуулах удирдамж” (№20230104) -ийн дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын байгууллагын барилга байгууламжид төлөвлөгөөт хяналт, шалгалтыг зохион байгуулсан байна.


Төлөвлөгөөт хяналт, шалгалтаар 32 боловсролын байгууллагын барилга байгууламжийг хамруулан 156 зөрчил дутагдал илрүүлж, 92 зөрчлийг арилгуулж, 64

зөрчлийг арилгуулахаар 20 албан шаардлага, гал түймрийн 12 улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл хүргүүлж хэрэгжилтийг хангуулсан байна.

3.3.2. Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийгдээгүй байна

Хүүхэд хамгааллын тухай хуулийг 2016 онд баталж, хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний үйл ажиллагааг хуульчилсан байна. Хүүхдийн тусламжийн 108 утас нь хүүхдийн эрхийг зөрчлийг мэдээлэх, үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх, мэдээлэл авах, холбон зуучлах зэрэг үйлчилгээ үзүүлдэг байна.

Дүрслэл №05 Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага, төрлөөр



Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээ

Хүүхдийн тусламжийн 108 утасны хандалтаас харахад 2019-2023 онд нийт дуудлагын 30-40% нь хүүхэд хамгааллын үйлчилгээ авах, 40-50% нь хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой дуудлага байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ авахаар хандсан дуудлагын тоо 2020, 2022 онд өмнөх онуудаас буурсан боловч 2023 онд хамгийн өндөр байна. Мөн Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой дуудлагын тоо 2020, 2023 онд бусад онтой харьцуулахад өндөр байна.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд хандсан хүүхдийг насны ангиллаар нь авч үзэхэд 2019 онд 5-9 насны хүүхдийн тоо хамгийн өндөр байсан бол, 2020, 2023 онд 15-17 насны, 2021, 2022 онд 10-14 насны хүүхдийн тоо хамгийн өндөр байна. Сүүлийн 2 жилд 10-14, 15-17 насны хүүхдийн хандалт бусад насны хүүхдүүдийн хандалтаас өндөр байна.

Аудитаар Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллах талаар

3.3.3. Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээ хүргүүлж байгаа боловч үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж чадаагүй байна

Аймгийн ХГБХХГ-аас 2019-2023 онд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг нас, хүйс, газар зүйн байршил, эрүүл мэнд, боловсрол, гэр бүлийн байдал зэрэг үзүүлэлтээр гаргаж, дүн шинжилгээ хийж, эрсдэлийн түвшин тогтоох ажлыг зохион байгуулсан байна.

Бүртгэгдсэн хүүхдийн гэр бүлд нь очиж нөхцөл байдлын үнэлгээ хийж, асран хамгаалагч нараас ярилцлага, нэмэлт мэдээлэл авч, амьдарч буй орчинд эрсдэлийн үнэлгээ хийж, хууль эрх зүйн болон нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгч мэдээллээр хангасан байна. Эдгээр хүүхдүүдэд хувцас хэрэглэлийн тусламж, шаардлагатай амин дэмийн багц, хүнсний тусламж дэмжлэг, хичээлийн хэрэгсэл, сургалт, нөлөөллийн ажил үйлчилгээг үзүүлж ажилласан байна.

Ковид-19 цар тахлын үед эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хүүхэд хамгааллын даатгал”-ын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн гэр бүлд дархлааг дэмжих бүтээгдэхүүн, амин дэм, хүнсний зүйлсээр дэмжлэг үзүүлэн, эрсдэлт нөхцөлд амьдарч буй гэр бүл, хүүхдийг илрүүлэх, хариу үйлчилгээ үзүүлэх ажлуудыг зохион байгуулж, эрүүл мэнд, ариутгалын багц, шаардлагатай бараа, бүтээгдэхүүний тусламж, дэмжлэгийг үзүүлсэн.

Хүүхдүүдийг даатгалд хамрагдуулснаар бүх төрлийн гэнэтийн осол, хүчирхийлэлд өртөх, алга болох, хууль зүйн туслалцаа авах, сэтгэл заслын эмчилгээнд хамрагдах, шүүх шинжилгээний зардал, аюулгүй байдлыг хангахтай холбогдон гарсан зардал, түр хамгаалах байранд авчрах тээврийн зардал, түр байрлахтай холбогдон гарсан зардлыг нөхөн төлбөрийг даатгалын компаниас гаргуулах боломж бүрдсэн байна.

Мөн хамгаалал шаардлагатай хүүхдэд зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээг үзүүлж, төрийн болон төрийн бус байгууллагад дэмжих, холбон зуучлах үйлчилгээ, гэр бүлд нь амьдрах ухаан олгох сургалт зохион байгуулан ажилласан байна.

Эрсдэлт нөхцөлд байгаа хууль ёсны төлөөлөгчийн үйлчилгээ, аюулгүй байдлыг хангах үйлчилгээ, гэр бүлийн дэмжих үйлчилгээ, хууль зүйн хорооны үйлчилгээ, дэмжих, холбон зуучлах үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээг тус тус үзүүлсэн байна.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд хариу үйлчилгээг үзүүлж байгаа боловч хүүхэд хамгааллын үйлчилгээ нэгдсэн нэг зохион байгуулалтад ороогүй, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, түүний гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн үзүүлэх, хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах, төсөв хөрөнгийн асуудал бүрэн шийдэгдээгүй байна.

Сумдад хүний нөөц, хариуцах албан тушаалтан байхгүй, алслагдсан хөдөө орон нутгуудад хүрч очих боломжгүй, машин техник шаардлага хангахгүй зэргээс шалтгаалан хариу арга хэмжээг түргэн шуурхай үзүүлж чадахгүй байна.


Хэдийгээр хариу үйлчилгээнд хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, асрамж халамжид хүлээлгэн өгсний дараа хяналт, дэмжлэг үзүүлэхээр байгаа боловч энэ үйлчилгээ хангалтгүй байна. Хөдөө сумуудад хүн ам цөөн, бие биенээ таньдаг учраас хүүхэд дахин эрсдэлд орсныг мэдэхэд хялбар байдаг бол аймгийн төвийн хүн ам ихтэй багийн хувьд кэйс хаагдсанаар тухайн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ зогсдог байна. Мөн хүүхэд хамгааллын нэгдсэн системгүйгээс хүүхэд нэг сумаас нөгөө сум руу эсвэл аймаг хооронд шилжихэд тухайн хүүхэд өмнө нь ямар үйлчилгээ авч байсныг мэдэх боломжгүй байна.

3.3.4. Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй холбоотой урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгаа боловч гэмт хэргийн тоо буураагүй байна

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 3 дугаар бүлэгт “Эрсдэлт нөхцөлд байгаа” хүүхдүүд буюу гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээ, үйлчилгээг тусгасан байна.

Аймгийн Цагдаагийн газарт 2019-2023 онд насанд хүрээгүй хүний 97 гэмт хэрэг бүртгэгдсэний 28 нь хүнд, 69 нь хөнгөн гэмт хэрэг байна.

Дүрслэл №07



Эх сурвалж: Аймгийн Цагдаагийн газраас

2023 онд бүртгэгдсэн насанд хүрээгүй хүний хөнгөн, хүнд гэмт хэргийн тоо өмнөх онуудтай харьцуулахад эрс өссөн үзүүлэлттэй байна. Насанд хүрээгүй хүний бүртгэгдсэн гэмт хэргийг үйлдэгдсэн орчноор нь харуулбал;

Дүрслэл №08




Эх сурвалж: Аймгийн Цагдаагийн газраас

Гэмт хэргийг үйлдэгдсэн орчноор нь авч үзэхэд гэр, орон сууц, аж ахуйн нэгж, гудамж тайлбай, олон нийтийн газар болон бусад орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг бусад гэмт хэргээс өндөр байна.

Насанд хүрээгүй хүний гэмт хэргийн хохирогчийг хүчирхийллийн төрлөөр нь авч үзвэл дараах байдалтай байна.

Дүрслэл №09



Эх сурвалж: Аймгийн Цагдаагийн газрын газраас

Бие махбодын хүчирхийллийн хохирогч 2020, 2023 он бусад онтой харьцуулахад өссөн, бэлгийн хүчирхийллийн хохирогч 2023 онд өссөн, харин авто тээврийн хэрэгслийн хохирогч буурсан үзүүлэлттэй байна.

Бэлгийн хүчирхийлэлд 2019-2023 онд 15 хүүхэд өртсөний дотор 6-11 насны 2, 12-18 насны 13 хүүхэд байна.

Хүснэгт №12 Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд

Огноо	Нийт хохирогч хүүхдийн тоо	Хохирогчийн нас			Хүчирхийлэгч, хохирогчийн хамаарал					
		0-5 нас	6-11 нас	12-18 нас	төрсөн эцэг	хойд эцэг	төрсөн ах, төрөл садан	эцэг эхийн танил, өөрийн найз	хөрш	үл таних хүн
2019	4	0	0	4	0	0	1	3	0	0
2020	0	0	0	0	0	0	0	0	0	0
2021	4	0	1	3			1	2		1
2022	1	0		1				1	0	
2023	6		1	5			3	2		1
Нийт	15	0	2	13	0	0	5	8	0	2

Эх сурвалж: Аймгийн Цагдаагийн газраас

Бэлгийн хүчирхийлэлд 2019-2023 онд 15 хүүхэд өртсөний дотор 6-11 насны 2, 12-18 насны 13 хүүхэд байна.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн 53 хувь нь эцэг эхийн танил, өөрийн найз, 33 хувь нь төрсөн ах, төрөл садан, 14 хувь нь үл таних хүний хүчирхийлэлд өртсөн байна.

Гэмт хэргийн улмаас 2019-2023 онд нийт 17 хүүхдийн амь нас хохирч, золгүй байдлаар буюу эцэг, эх харгалзан дэмжигчийн анхаарал болгоомжгүй явдлаас болж усанд живэх, угаартах, моринд чирэгдэх зэргээр 21 хүүхэд амь насаараа хохирсон байна.

Аймгийн Цагдаагийн газраас насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчил, цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр жил бүр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран орон нутгийн телевиз, радиогоор сэрэмжлүүлэг мэдээ мэдээлэл, цуврал подкаст нэвтрүүлгийг олон нийтэд түгээсэн байна.

“Хүүхэд хамгаалал”, “Болзошгүй эрсдэл” “Угаараас урьдчилан сэргийлье”, “Гол усны аюулаас урьдчилан сэргийлье”, “Эргүүл хяналт”, “Хяналт шалгалт”, “Нуугдмал” “Хичээл амарлаа”, “Зуслан”, “Хичээл эхэллээ” сэдэвт цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, танхимаар гэмт

хэргээс урьдчилан сэргийлэх талаар танилцуулга хийж, зурагт хуудас бүхий нөлөөллийн хуудас тарааж, гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгүүдэд эргүүлийн үүрэг гүйцэтгэж, гэмт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүүхдүүдийн дунд уралдаан тэмцээн зохион байгуулсан байна.

Хичээл тарах, сургуулийн улирлын амралтын үед аймгийн Боловсролын газартай хамтран ЕБС-ын багш, нийгмийн ажилтнуудыг 18 удаа нийтийн эргүүлд татан оролцуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд давхардсан тоогоор 120 тооны мэдэгдэл шаардлага хүргүүлж биелэлт, үр дүнг тооцож ажилласан байна.

Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн талаарх гарч буй гэмт хэргийн шалтгааныг судалж үзэхэд ихэвчлэн эцэг эх, асран хамгаалагч нарын бага насны болон өсвөр насны хүүхдүүдэд тавих хараа хяналт сул, эцэг эх, асран хамгаалагч нарын хүүхдийн хөгжил, хүмүүжил, хүүхдийн эрх, хамгааллын талаарх мэдлэг дутмаг, эцэг эх, асран хамгаалагчийн сэтгэц, эрүүл мэнд, боловсролын түвшин доогуур, гэр бүлийн харилцааны асуудал, эцэг эх, асран хамгаалагчдын хоорондох хүчирхийлэл, архидалт, донтолт, ажилгүйдэл, стресс, бухимдал, орон байрны асуудал, зодож шийтгэхийг дэмжсэн, зөвшөөрсөн нийгмийн хандлага, замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн, багш, сурган хүмүүжүүлэгч нарын зүгээс сургуулийн орчинд гэмт хэргийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй ажил, арга хэмжээ үр дүн багатай, эцэг эх, асран хамгаалагч нар боловсролын байгууллагатай нягт хамтран ажилладаггүйтэй холбоотой байна.

Иймд хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэхийг дэмжсэн нийгмийн хандлагыг бий болгох, хүүхдэд бага наснаас нь чанартай боловсрол олгох, хүмүүжүүлэх үйлчилгээ үзүүлэх, эцэг эх, асран хамгаалагчийн чадварыг нэмэгдүүлэх, гэмт хэргийн хор хөнөөлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг зодож шийтгэхээс үүсэх сөрөг нөлөөг таниулах, хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэхийг дэмжих, сургах, зодож шийтгэхийг хориглосон хуулийн заалтын хэрэгжилтийг хангах, хор хөнөөлийг бууруулах, гэр бүлийн харилцааг (үл хайхрах, сэтгэл зүйн дарамт, зодож шийтгэх) дэмжсэн тусламж, үйлчилгээг хүртээмжтэйгээр хүргэх, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчныг бий болгох, хор хөнөөлийг бууруулах, ирээдүйн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулах шаардлагатай байна.

Аудитаар гэмт хэрэг гарч буй суурь шалтгааныг нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн ХГБХХГ-т зөвлөмж болгов.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- 1.Хүүхэд хамгааллын талаарх зорилт арга хэмжээг үйл ажиллагааны хөтөлбөр, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн байна
- 2.Хүүхэд хамгааллын чиг үүрэг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа харилцан уялдаагүй, зарим чиг үүрэг хэрэгжээгүй байна
- 3.ХГБХХГ хүүхэд хамгааллын үйлчилгээг зохих журмаар хэрэгжүүлж ажилласан байна
- 4.Хүүхэд хамгааллын үйл ажиллагаагны санхүүжилт, хүний нөөцийн дутагдалтай байна
- 5.Боловсролын салбараас бусад салбаруудад шалгуур үзүүлэлт, аргачлал байхгүй
- 6.Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээг жил бүр тайлагнаж ажилласан байна
- 7.Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт гэр бүлийн орчинд бүрэн нөлөөлж чадаагүй байна
- 8.Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлого бүрэн хэрэгжээгүй байна.
- 9.Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээг түргэн шуурхай үзүүлж чадаагүй байна
- 10.Хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I.Аймгийн Засаг дарга /А.Камелият/-д:

- 1.Хүүхэд хамгаалал, хөгжлийн талаар аймгийн онцлогт тохируулан бодлого, төлөвлөгөө боловсруулж, чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах;

II.Аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газар /Х.Бауыржан/-т:

- 1.Хүүхэд хамгаалал, хөгжлийн талаар орон нутгийн онцлогт тохируулан бодлого, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;
- 2.Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн мэдээлэл тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж ажиллах эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллах

3.Цахим орчин дахь хүүхэд хамгааллын мэдээлэл тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж ажиллах

4. Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага, мэдээлэлд тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж ажиллах

5. Гэмт хэрэг гарч буй суурь шалтгаан, мэдээлэл тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллах

III.Аймгийн Боловсролын газар /С.Хонаев/-т:

1. ЕБС хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхдээ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх;

2.Сургуулиудын гадаад, дотоод орчинд эрсдэлийн үнэлгээ хийж, өндөр эрсдэлтэй үйл ажиллагааны жагсаалтыг гаргуулан, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авах;

3.Хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоож, хүчирхийллээс үүдэлтэй эсэхэд тандан судалгаа хийж ажиллах;

4.Салбарын харья байгууллагуудад яаралтай үед хүүхэд ашиглаж болох утасны цэг, анхны тусламжийн хайрцгийг тодорхой цэгт байрлуулж ажиллуулах;

5.Багш, ажилтныг ажилд авахдаа өмнөх ажилласан газрын ажлын байрны тодорхойлолт, хүчирхийлэл, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг авч хувийн хэрэгт хавсаргах;

6.Багшийн ёс зүйн дүрмийг шинээр ажилд орсон багш, ажилтанд заавал танилцуулж, хүлээн зөвшөөрсөн гарын үсгийг зуруулж ажиллах;

7.Холбогдох албан тушаалтнуудын ажлын тайлан болон холбогдох мэдээ, мэдээллийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын дагуу архивын хадгаламжийн нэгж үүсгэж хадгалах;

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:

Хүүхэд хамгааллын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, холбогдох журамд дараах өөрчлөлтийг оруулахаар Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлэхээр санал болгож байна.

1.Салбарын онцлогт нийцсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлал журам баталж, хэрэгжүүлэх талаар төрийн захиргааны төв байгууллагуудад зөвлөмж өгөх;

2. Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод нэгдсэн үүргийн хэрэгжилт, хүүхэд хамгааллын чиглэлээр ОУБ-аас Засгийн газарт өгсөн зөвлөмжийн биелэлт, Олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудаас хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнг тооцон, нэгтгэн дүгнэж, биелэлтийг хууль тогтоомжид заасан хугацаанд аймгуудаас авч ажиллах талаар Засгийн газарт зөвлөмж хүргүүлэх;

3.Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллыг сайжруулахын тулд хүүхэд хамгааллын бодлогыг боловсронгуй болгох, хамтарсан багт ажилладаг цагдаа, өрхийн эмнэлгийн ажилтнуудын ажил үүргийн хуваарьт хүүхэд хамгааллын ажлыг оруулах, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв буюу хүүхэд хамгааллын зардлыг нэмэгдүүлэх талаар Засгийн газарт зөвлөмж хүргүүлэх;

4. Хүүхдийн эрхийг зөрчсөн вэб сайтыг мэдээлэх цахим талбар, эцэг эхийн хяналтын аппликэйшн зэргийг хөгжүүлж, сургуулийн орчинд гар утас ашиглахыг хязгаарлах эрх зүйн акт гаргах талаар санал хүргүүлэх;

5.Баг, хорооны хамтарсан баг, эцэг, эхийн оролцоог сайжруулах, нийгмийн ажилтантай нягт хамтарч ажиллах, оролцогч талуудын үүрэг, хариуцлагын талаар хууль тогтоомж, бодлогод өөрчлөлт оруулах талаар санал хүргүүлэх;

6.Сургуулийн насны хүүхдүүдэд электрон тамхины хэрэглээг хориглох талаар холбогдох хуульд тусгах;

7.Цахилгаан дугуй, мопед зэрэг техникийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахад насны хязгаар тогтоох талаар замын хөдөлгөөний дүрэмд өөрчлөлт оруулах;

8.Хүүхэд хамгааллын төсвийг нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын зардлыг эдийн засгийн ангиллаар төсөвт тусгах талаар санал дэвшүүлэх;

9.Эрүүл мэндийн салбарт хүүхэд хамгааллын бодлогыг хангуулах талаар Эрүүл мэндийн сайдад зөвлөмж хүргүүлэх;